

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 09 өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.9 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 2.3.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Архивын Улсын ахлах байцаагчийн 2025 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн Зөрчил арилгах тухай 09/74 дүгээр албан шаардлагаар илэрсэн зөрчлийг архилгах хүрээнд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг жил бүр батлуулах, архивт хүлээн авсан баримтыг ангилан төрөлжүүлж данс, бүртгэл үйлдэх, архивын хадгаламжийн санд мэргэжлийн байгууллагаар галын дүгнэлт гаргуулахыг ажил зохион байгуулж тайлагнахыг Архив, албан хэрэг, хөтлөлт, цахим мэдээллийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Г.Анударьд үүрэг болгосугай.

2.Архивын баримт үүсгэхдээ хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан баримт үүсгээгүй, ангилан төрөлжүүлээгүй, баримтын бүрдэл дутуу 2021-2024 оны зөрчилтэй баримтуудыг нөхөн бүрдүүлж, зөрчил арилгах үйл ажиллагааг зохион байгуулахыг хэлтсийн дарга, Архив, албан хэрэг, хөтлөлт, цахим мэдээллийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Г.Анударьд нарт тус тус үүрэг болгосугай.

3.Монгол хэлний дүрэм, утга найруулгын алдаагүй албан бичиг боловруулж Баримт бичгийн стандартын шаардлага хангаж ажиллахыг нийт албан хаагчдад, Баримт бичгийн стандартын шаардлага хангуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллахыг Бичиг хэрэг бөгөөд даргын туслах нарт тус тус даалгасугай.

4.Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан хэлтсийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж тайлагнахыг Дотоод хяналт, шалгалт, үнэлг

ээ хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Баялаг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БОЛОРТУЯА